



ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН 2018 ОНЫ ХЯНАЛТЫН ТАЙЛАН

АГУУЛГА

ТОВЧ ХУРААНГУЙ	1
1. ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ХЯНАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ЗАРЧМУУД.....	2
<i>Үндэсний төлбөрийн систем гэж юу вэ?</i>	2
<i>Төлбөрийн системийн эрсдэл</i>	2
<i>Төлбөрийн системийн хяналт гэж юу вэ?</i>	3
<i>Төлбөрийн системийн хяналтын зарчмууд</i>	3
2. МОНГОЛБАНКНААС ТАВИХ ХЯНАЛТЫН ХАМРАХ ХҮРЭЭ.....	4
<i>Банксүлжээ систем</i>	4
<i>Бага дүнтэй төлбөрийн систем</i>	5
<i>Картын нэгдсэн сүлжээ</i>	6
<i>Төлбөрийн хэрэгсэл</i>	6
3. МОНГОЛБАНКНААС ХЯНАЛТЫН ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ	7
<i>Төлбөрийн системийн хяналтын хууль эрх зүйн зохицуулалт</i>	7
<i>Төлбөрийн системийн хяналтын үйл ажиллагаа</i>	8
1. Шаардлагатай мэдээлэл цуглуулах	8
2. Хяналт тавих.....	9
3. Үнэлгээ хийх.....	10
4. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх	11
5. Шаардлагатай өөрчлөлт хийх	11

ТОВЧ ХУРААНГУЙ

Монголбанкнаас хэрэгжүүлж буй төлбөрийн системийн хяналттай холбоотой үйл ажиллагааг нийтэд ил тод болгох зорилгоор “Үндэсний төлбөрийн системийн хяналтын тайлан”-г жил бүр гаргадаг. Энэ тайлан нь төлбөр системийн оператор болон төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид, дотоодын болон олон улсын зохицуулагч байгууллагууд, хэрэглэгчдэд Монголбанкнаас төлбөрийн системд тавих хяналтын ач холбогдол, зорилгыг ойлгуулах зорилготой юм.

Тайлан дараах 3 бүлэгтэй.

1. Төлбөрийн системийн хяналтын талаарх олон улсын зарчмууд;
2. Монголбанкнаас тавих хяналтын хамрах хүрээ;
3. Монголбанкнаас хяналтын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ.

1. ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ХЯНАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ЗАРЧМУУД

Үндэсний төлбөрийн систем гэж юу вэ?

Төлбөрийн систем гэж төгрөг, валютаар хийгдэх шилжүүлэг болон төлбөрийн даалгаврын боловсруулалт хийх, илгээх, дамжуулах, хүлээн авахтай холбогдох үйлчилгээ, төлбөрийн хэрэгсэл гаргах үйл ажиллагаа, төлбөрийн, клирингийн болон төлбөр тооцооны систем, Монгол Улсын нутаг дэвсгэрт хэсэгчлэн болон бүхэлд нь үйл ажиллагаа эрхэлж байгаа системийн оператор, оролцогч, тэдгээрийн нэрийн өмнөөс төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч гуравдагч этгээд, тэдгээрийн цогц нэгдэл билээ.

Төлбөр, мөнгөн гуйвуулга, үнэт цаасны клиринг, төлбөр тооцооны системүүд нийт эдийн засагт, ялангуяа санхүүгийн систем болон мөнгөний эргэлтийн хэвийн үйл ажиллагаанд нэн чухал үүрэг гүйцэтгэдэг. Эдгээр системийн үр

ашигтай, хэвийн ажиллагаа нь байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн, бизнес эрхлэгчдэд санхүүгийн үүргээ биелүүлэх, мөнгөн хөрөнгөө аюулгүй шилжүүлэх боломж олгодог.

Төлбөрийн системийн эрсдэл

Олон улсын төлбөр тооцооны банкнаас төлбөрийн системд зээлийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын, системийн, хууль эрх зүйн, үйл ажиллагааны, төлбөр тооцооны, бизнесийн эрсдэл үүсч болно гэж тодорхойлсон байна.

Зөв зохион байгуулж, удирдаж чадсан төлбөрийн болон төлбөрийн систем нь санхүүгийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн өсөлтийг дэмжих сайн талтай. Үр ашигтай, аюулгүй, найдвартай ажиллагаатай төлбөрийн системийн тусламжтайгаар бараа, үйлчилгээний зардлыг бууруулж, санхүүгийн зах зээл, арилжааны гүйлгээ, хөрөнгө оруулалт болон эдийн засгийн бусад үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах боломж бүрддэг. Харин эдгээр системүүдийн үйл

ажиллагааны доголдол нь санхүүгийн зах зээл дээр хүндрэл үүсгэх, ялангуяа зах зээлийн хямралын үед хямралыг даамжруулах эх үүсвэр болдог. Төлбөр системийн үр ашиггүй байдлаас шалтгаалж хэрэглэгчийн зардал өсч, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд саад учирдаг. Илүү өргөн хүрээнд авч үзвэл дээр дурдсан асуудлууд нь санхүүгийн систем болон үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх олон нийтийн итгэлд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

Төлбөрийн системд зээлийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын, системийн, хууль эрх зүйн, үйл ажиллагааны, төлбөр тооцооны, бизнесийн зэрэг эрсдэл үүсдэг. Системийн хэмжээнд гүйлгээний тоо болон дүн хурдацтай өсөхийн хэрээр төлбөрийн системийн эрсдэлийн хэмжээ ихэснэ. Өндөр түвшний технологи нэвтрэхтэй зэрэгцэн шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгслүүд болон төлбөр төлөх арга нэмэгдэж, төлбөрийн системийг нийтэд нь нарийн төвөгтэй, олон талт болгож байна.

Мөн сүүлийн жилүүдэд хувийн хэвшлийн зүгээс төлбөрийн үйлчилгээ үзүүлэх нь хурдацтай өргөжиж, банк бус эсвэл санхүүгийн бус байгууллага тус зах зээлд хүч түрэн орж байна. Энэ хандлага нь нарийн төвөгтэй нөхцөл байдлыг үүсгэж, эрсдэлийг нэмэгдүүлж байгаа учраас төлбөр систем болон клирингийн дэд бүтэц, төлбөрийн зохицуулалтыг бүхэлд нь хамарсан цогц хяналтыг хэрэгжүүлэх шаардлага бий болоод байна.

Төлбөрийн системийн хяналт гэж юу вэ?

Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн хэрэгсэл гаргагч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагааг эрхлэх эрх бүхий этгээд болон операторын зохистой засаглал, удирдлага, үйл ажиллагаа, хэрэглэгчтэй холбогдох харилцаа, систем хоорондын хамаарлыг зохицуулсан журам, дүрэм, шийдвэрийн хэрэгжилтэд нь хяналт тавихыг хэлнэ.

Төлбөрийн системийн хяналтын зорилго нь системийн эрсдэлийг хязгаарлан, хэрэглэгч болон эдийн засгийн хэрэгцээг хангаж, найдвартай, үр ашигтай ажиллаж байгааг баталгаажуулахад оршино. Энэ нь түүнд тогтоосон стандарт болон хяналтын бодлогын шаардлагын дагуу тодорхой системийг үнэлэхээс гадна эдийн засаг дахь төлбөр тооцооны зохицуулалтыг бүхэлд нь бэхжүүлэхэд чиглэсэн маш өргөн үйл ажиллагааг хамардаг.

Төлбөрийн системийн хяналтын үүрэг нь банкны хяналт шалгалтаас ялгаатай ойлголт

билээ. Банкны хяналт шалгалт нь тухайн нэг банкны санхүүгийн байдлыг нэг бүрчлэн хянаж, шалгадаг бол төлбөрийн системийн хяналт нь систем, түүний оролцогч, төлбөрийн хэрэгслийг бүхэлд нь хяналт тавьж өргөн хүрээнд авч үздэг байна.

Төлбөрийн системийн хяналтын зарчмууд

Төв банкны төлбөрийн системийн хяналтын чиг үүрэг нь Олон улсын төлбөр тооцооны банкны Төлбөрийн болон зах зээлийн дэд

бүтцийн хороо (ТЗЗДБХ)-оос боловсруулан гаргасан олон улсад нийтлэг мөрдөх тодорхой зарчмуудад тулгуурладаг. Тус хорооноос 2005 онд гаргасан “Төв банкны хяналтын тайлан”-д¹

дотоодын болон олон улсын хэмжээнд төлбөр тооцооны системүүдэд хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх үндсэн 5 зарчмыг тодорхойлсон.

1. Төв банк нь өөрийн хяналтын бодлогоо олон нийтэд мэдээлэх ёстой ба ингэхдээ систем бүрт тавигдах бодлогын шаардлага эсвэл стандартууд мөн аль системд хамаарахыг тогтоох шалгуурууд зэргийг тодорхойлно.
2. Төв банк нь төлбөрийн системүүдэд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн холбогдох стандартыг мөрдүүлэх ёстой.
3. Төв банк нь хяналтын үүрэг хариуцлагаа үр дүнтэй хэрэгжүүлэх бүрэн эрх, чадавхтай байх ёстой.
4. Төв банкны ажиллуулдаг системүүд, бусад төлбөрийн системүүдэд хяналтын стандартуудыг тогтмол мөрдүүлэх ёстой.
5. Төлбөрийн системүүдийн аюулгүй, үр ашигтай байдлыг дэмжихийн тулд төв банк нь бусад төв банкууд болон эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах ёстой.

Дээрх “Төв банкны хяналтын тайлан”-аас гадна ТЗЗДБХ болон Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (ҮЦХОУБ)-аас хамтран гаргасан “Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц (СЗЗДБ)-

ийн зарчим”-д² СЗЗДБ-ийн хяналт, зохицуулалт, шалгалттай холбоотойгоор эрх бүхий байгууллагын хүлээх 5 үүрэг хариуцлагыг тодорхойлсон байдаг.

2. МОНГОЛБАНКНААС ТАВИХ ХЯНАЛТЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд заасны дагуу Монголбанк нь үндэсний төлбөрийн систем (ҮТС)-ийн найдвартай, үр ашигтай байдлыг хангах бүрэн эрхийн хүрээнд төлбөрийн системийн хяналтын хамрах хүрээг тодорхойлно. Монголбанк нь дараах төлбөрийн систем болон төлбөрийн

хэрэгсэлд хяналт тавих үүргийг хүлээдэг.

Банксүлжээ систем

Монголбанкны Бодлого зохицуулалт, үйл ажиллагааны хэлтэс (БЗҮАХ)-ийн хариуцан ажиллуулж буй их дүнтэй төлбөр систем буюу Банксүлжээ(Real-Time Gross Settlement) систем нь

¹ <https://www.bis.org/cpmi/publ/d68.pdf>

² <http://www.bis.org/cpmi/publ/d101a.pdf>

Монгол Улсын үндэсний төлбөрийн системийн суурь юм. Энэ системд 14 банк, банкны эрх хүлээн авагч 2, Хөгжлийн банк, Сангийн яамны Төрийн сангийн газар, Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК холбогдсон.

Оролцогчийн харилцах дансыг Монголбанкинд байршуулж, Банксүлжээ систем нь эдгээр системийн оролцогч хооронд хийгдэж буй их дүнтэй төлбөр нэг бүрийг бодит цагийн горимоор гүйцэтгэдэг.

Түүнчлэн Үндэсний цахим гүйлгээний төвөөр (цаашид ҮЦГТ гэх) тухайн өдөрт дамжсан оролцогч хоорондын бага дүнтэй болон картын үр дүнгийн тооцооллын хаалтын дүнг дараагийн ажлын өдөрт нь холбогдох дансанд тусгаж байна. Дэлхий нийтээр бодит цагийн горимд ажилладаг их дүнтэй төлбөрийн системийг системийн хувьд нэн чухал систем гэж тооцож, Төв банкны эзэмшилд байлгадаг.

Банксүлжээ системийн үйл ажиллагааг Монголбанкны Ерөнхийлөгчийн (цаашид МБЕ гэх) 2018 оны А-88 тоот тушаалаар батлагдсан “Их дүнтэй төлбөрийн системийн журам”-аар³ зохицуулж байна. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй

Төлбөрийн системийн шинэчлэл төслийн хүрээнд Банксүлжээ системийн програм хангамжийг 2 дугаар үед (2nd generation RTGS) нэвтрүүлэх ажил амжилттай явагдаж 2018 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр бүрэн ашиглалтанд оруулсан. Тус системээр Монгол Улсын төлбөрийн системд дансны нэгдсэн дугаарлалтыг нэвтрүүлснээр олон улсын төлбөр тооцоо гүйцэтгэхэд илүү хялбар болох, банк хоорондын төлбөр тооцоонд одоогийн ашиглаж байгаа дансдын давхцал арилах, банкны ажилтан дансны дугаарыг шивэх явцдаа тухайн данс зөв эсэхийг шалгах зэрэг боломжууд нэмэгдэж байна. Түүнчлэн Банксүлжээ системд буцаалтын гүйлгээ хийх, оролцогч хоорондын валютын гүйлгээ хийх, оролцогчийн дансанд барилт хийх зэрэг боломж нэмэгдэж, тус систем санхүүгийн байгууллага хоорондын цахим мэдээ солилцох олон улсын ISO20022 стандартад бүрэн шилжсэн.

Бага дүнтэй төлбөрийн систем

Монголбанкны ҮЦГТ-ийн хариуцан ажиллуулдаг бага дүнтэй төлбөрийн систем нь оролцогч хоорондын кредит шилжүүлгийн систем юм. Бага дүнтэй гүйлгээний мөнгөн дүнгийн дээд хязгаар 1 сая төгрөг байсныг 3 сая төгрөг болгож 2018

³

<https://www.mongolbank.mn/documents/regulation/paymentsystem/ihduntei.pdf>

оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэн. Бага дүнтэй төлбөрийн системийг олон улсад жижиглэнгийн төлбөрүүдэд зориулсан системийн нэг төрөл гэж үздэг. Тус системийн оролцогчид нь банкууд, Хөгжлийн банк, Сангийн яамны Төрийн сангийн газар, Арилжааны төлбөр тооцоо ТӨХХК, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ТӨХХК байна.

Энэ системийн үйл ажиллагааг МБЕ-ийн 2017 оны А-316 тоот тушаалаар батлагдсан “Бага дүнтэй төлбөрийн системийн журам”-аар⁴ зохицуулж байна.

Картын нэгдсэн сүлжээ

Оролцогч хоорондын картын нэгдсэн сүлжээ нь АТМ-аас бэлэн мөнгө авах, шилжүүлэг хийх, ПОС төхөөрөмж дээр бараа үйлчилгээний төлбөр төлөх, цахим худалдан авалт зэрэг төлбөрийн картаар хийх гүйлгээг боловсруулах жижиглэнгийн төлбөрүүдэд зориулсан систем юм. Картын нэгдсэн сүлжээг ҮЦГТ хариуцан ажиллуулж, тухайн өдөрт төлбөрийн системийн оролцогч хооронд дамжсан гүйлгээнүүдийн үр дүнгийн тооцооллын хаалтын дүнг Банксүлжээ системд дамжуулснаар төлбөр тооцоо хийгддэг. Картын нэгдсэн

сүлжээний шууд оролцогчид нь Капитал банк, Худалдаа хөгжлийн банк (ХХБ), ХААН банк, Голомт банк, Хас банк, Төрийн банк бөгөөд бусад банкууд дэд гишүүнээр холбогдон, ХХБ-ны клирингийн сүлжээгээр өөрийн картын гүйлгээг дамжуулж, картын нэгдсэн сүлжээнд холбогдож байна.

Картын нэгдсэн сүлжээний үйл ажиллагааг МБЕ-ийн 2017 оны А-327 тоот тушаалаар батлагдсан “Банкны төлбөрийн картын журам”⁵-аар зохицуулж байна. Клирингийн төв нь Монголбанкнаас “Банкны төлбөрийн картын журам”-д заасны дагуу үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө авч, картын гүйлгээг дамжуулах, дэд гишүүн банкны үр дүнгийн тооцооллыг хийдэг байгууллага юм. Одоогийн байдлаар ХХБ клирингийн зөвшөөрөл авч, өөрийн сүлжээнд 7 дэд гишүүн банктайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Төлбөрийн хэрэгсэл

Төв банк нь шинэлэг төлбөрийн хэрэгсэл болон хандалтын сувгуудын найдвартай, үр ашигтай байдал, хэрэглэгчийн мөнгөн хөрөнгийг хамгаалахад анхаардаг тул төлбөрийн карт, цахим мөнгө, хөдөлгөөнт төлбөр тооцоо гэх мэт шинэлэг

4

<https://www.mongolbank.mn/documents/regulation/paymentsystem/bagaduntei.pdf>

5

<https://www.mongolbank.mn/documents/regulation/paymentsystem/2017/20171225A327.pdf>

төлбөрийн хэрэгслүүдийг өөрийн хяналтын хамрах хүрээнд оруулдаг.

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 8.2-д заасны дагуу төгрөгийг орлох төлбөрийн бусад хэрэгслийн зөвшөөрлийг

Монголбанк олгодог. Одоогоор Монголбанкны зөвшөөрөлтэй төгрөгийг орлох төлбөрийн хэрэгсэл нь төлбөрийн карт, цахим мөнгө байна. Банкууд төлбөрийн карт гаргах, хүлээн авах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг авахдаа “Банкны төлбөрийн картын журам”-ын дагуу шаардлагатай материалыг бүрдүүлэн хүсэлтээ гаргаж, Монголбанкинд ирүүлж байна. Хяналт зохицуулалтын хэлтэс (цаашид ХЗХ гэх) холбогдох материалд ирүүлсэн журам, заавар, гэрээ, бусад баримт бичгийг дүгнэж, шаардлага

хангасан нөхцөлд картын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог. Үүнтэй холбоотойгоор 2018 онд 1 банкинд 2 нэмэлт зөвшөөрөл олгож, 1 банкны 1 нэмэлт зөвшөөрлийг цуцалж, 1 банкны зөвшөөрлийг сунгасан.

Цахим мөнгө гаргах үйл ажиллагааг МБЕ-ийн 2018 оны А-45 тоот тушаалаар батлагдсан “Цахим мөнгөний журам”⁶-аар зохицуулдаг.

Монголбанк нь цахим мөнгө гаргах үйл ажиллагаа эрхлэх анхны зөвшөөрлийг 2018 оны 9 дүгээр сард Мобифинанс ББСБ олгосон.

Монголбанкнаас олгосон төлбөрийн карт гаргах, хүлээн авах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Хавсралт 1-д, цахим мөнгө гаргах зөвшөөрлийг Хавсралт 2-т үзүүлээ.

3. МОНГОЛБАНКНААС ХЯНАЛТЫН ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Монголбанкнаас хэрэгжүүлж буй төлбөрийн системийн хяналтын үүрэг нь төлбөр тооцооны системүүдийг болон төлбөрийн зохицуулалтыг үүсэж болзошгүй эрсдэлээс хангалттай хэмжээнд хамгаалж байгааг, түүнчлэн системийн бүтэц, тухайн системийг Төв банк эсвэл хувийн хэвшил хариуцан ажиллуулж байгаа эсэхээс үл хамааран үр ашигтай ажиллаж байгааг баталгаажуулах явдал юм.

Төлбөрийн системийн хяналтын хууль эрх зүйн зохицуулалт

Олон улсад нийтлэг мөрдөгдөх зарчмуудад Төв банкиг хяналтын зорилгод нийцүүлэн хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэх хууль ёсны онцгой эрхтэй, хүчин

6

https://www.mongolbank.mn/documents/regulation/paymentsystem/2018/20180419_eMoney.pdf

чадалтай байхыг шаарддаг. Төв банк (Монголбанк)-ны тухай хуулинд Монголбанк нь үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавихаар заасан.

Монголбанкинд Дэлхийн банкнаас “Төлбөрийн системийн хууль эрх зүйн орчныг сайжруулах, хяналтын чадавхыг бэхжүүлэх” зорилгоор техник туслалцаа үзүүлж байгаа бөгөөд техник туслалцааны дэмжлэгтэйгээр “Үндэсний төлбөрийн системийн тухай” хуулийн төслийг боловсруулан, УИХ-аар 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдөр батлуулсан. Энэ хууль энэ оноос эхлэн хэрэгжиж байна. Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд Монголбанк нь ҮТС-ийг бүхэлд нь болон бүрэлдэхүүн хэсгүүдийг зохицуулах, хянах талаар тусгаж, ҮТС-д хяналт тавих үүргийг Монголбанкинд хүлээлгэсэн.

Монголбанкнаас төлбөрийн системийн хяналтыг хэрэгжүүлэхдээ МБЕ-ийн 2016 оны А-265 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн системийн хяналтын бодлого”-ыг⁷ удирдлага болгодог, ХЗХ-ийн хянан шалгагчид үйл ажиллагаандаа МБЕ-ийн 2015 оны

А-76 тушаалаар батлагдсан “Төлбөрийн системийн оролцогчдын үйл ажиллагаанд газар дээр нь шалгалт хийх журам”-ыг⁸ мөрдөж ажилладаг.

Төлбөрийн системийн хяналтын үйл ажиллагаа

Монголбанк төлбөрийн системийн хяналтыг хэрэгжүүлэхдээ дараах үндсэн 5 үйл ажиллагааг явуулж байна.

1. Шаардлагатай мэдээлэл цуглуулах

ХЗХ-ийн хянан шалгагч нар нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн дагуу төлбөрийн системийн оролцогчдоос шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь гаргуулан авах бүрэн эрхтэй байдаг. Холбогдох журмуудад үндэслэн оролцогчид гүйлгээний тоон мэдээллийг тогтмол ирүүлдэг. Тоон мэдээллийг нэгтгэн улирал бүр төлбөрийн системийн тайланг Монголбанкны цахим хуудсанд⁹ байршуулж нийтэд ил тод болгодог. Хяналтанд хамрагдаж байгаа төлбөрийн системүүд 7 хоног бүр тухайн системээр дамжсан амжилттай болон амжилтгүй гүйлгээний мэдээлэл, тасралтгүй найдвартай ажиллагааны үзүүлэлт зэргийг

⁷

https://www.mongolbank.mn/documents/regulation/paymentsystem/2016/20160928_A265.pdf

⁸

https://www.mongolbank.mn/documents/regulation/paymentsystem/2015/20150428_A76.pdf

⁹ <https://mongolbank.mn/liststatistic.aspx?id=15>

багтаасан үйл ажиллагааны тайлан гаргаж, ХЗХ-т ирүүлж байна. Энэ үйл ажиллагааны тайланг сар бүр нэгтгэн, Монголбанкны удирдлагад танилцуулж, мэдээллээр хангаж байна.

2. Хяналт тавих

ХЗХ нь оператор болон оролцогчийн эрх зүйн баримт, мэдээлэл, статистик үзүүлэлтүүдийг тодорхой давтамжтайгаар цуглуулж, дүрэм, журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавин ажиллаж байна. Газар дээрх хийсэн шалгалтын үр дүнг системийн найдвартай, үр ашигтай байдлын үнэлгээнд ашигладаг. Төлбөрийн системийн оролцогч бүх банкуудад иж бүрэн

шалгалтыг 2018 онд хийж гүйцэтгэсэн ба шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрт мэдэгдэж, залруулах талаар хянан шалгагч нар өөрийн бүрэн эрхийн хүрээнд арга хэмжээ авч ажиллалаа.

Түүнчлэн банкуудаас системийн хэмжээний тайланг гаргуулан авч, мониторинг хийх бөгөөд тоон мэдээнд үндэслэн хяналт шинжилгээ хийж байна. Улирал тутам гаргаж буй төлбөрийн системийн тайлан, мэдээг Монголбанкны цахим хаягаас¹⁰ авах боломжтой.

Дараах хүснэгтэд 2015-2017 онд их болон бага дүнтэй төлбөрийн систем, картын нэгдсэн сүлжээгээр дамжсан гүйлгээний тоо ба дүнг харуулав.

Хүснэгт 1 (мянган ширхэг, их наяд төгрөг)

Систем	2015		2016		2017	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Их дүнтэй	1 419,2	57,9	1 521,5	54,0	1 902,4	67,1
Бага дүнтэй	20 794,8	1,8	30 347,9	3,2	24 179,4	3,7
Картын нэгдсэн сүлжээ	44 553,8	2,2	65 580,6	2,8	97 057,6	3,8

Хүснэгт 1-ээс харахад жилийн дундаж өсөлт их дүнтэй гүйлгээний тоо 16 хувь, дүн 9 хувь, бага дүнтэй гүйлгээний тоо 13 хувь, дүн 47 хувь, картын нэгдсэн сүлжээний гүйлгээний тоо 48 хувь, дүн 31 хувь тус тус өссөн үзүүлэлтэй байна.


Хяналт зохицуулалтын хэлтэс нь төлбөрийн системийн оператор болон оролцогчдын тасралтгүй найдвартай ажиллагаанд тогтмол хяналт тавин ажиллаж байна. Банксүлжээ системд 2018 оны 11 дүгээр сарын байдлаар 388 минут, бага дүнтэй төлбөрийн системд

¹⁰ <https://mongolbank.mn/liststatistic.aspx?id=15>

нийт 262 минут, картын нэгдсэн сүлжээнд нийт 386 минутын тасралтууд тус тус үүссэн. Клирингийн сүлжээнд тасралт гараагүй. Эдгээр тасралтуудын гол шалтгаан нь цахилгааны

автомат гал хамгаалагч эвдрэх, техник болон програм хангамж, өгөгдлийн сангийн алдаа зэрэг үйл ажиллагааны эрсдэл үүссэн байна. Системийн тасралтгүй байдлыг График 1-ээс үзнэ үү.

График 1



3. Үнэлгээ хийх

СЗЗДБ-ийг үнэлэх “Үнэлгээний аргачлал”-ыг МБЕ-ийн 2015 оны А-98 тоот тушаалаар баталсан¹¹ бөгөөд уг аргачлалын дагуу жил бүр системийн хувьд нэн чухал төлбөрийн системд үнэлгээ хийдэг. Энэ үнэлгээг хийснээр төлбөрийн системд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлон, түүнийг үнэлэх, бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломж бүрдэж байна.

Монголбанк нь тухайн системээр боловсруулж буй гүйлгээний дундаж дүн, гүйлгээний төрөл, хэрэглэгчийн тоог харгалзан үзсэний үндсэн дээр төлбөрийн системийг системийн хувьд нэн

чухал эсэхийг шийддэг. Одоогийн байдлаар энэ шалгуур үзүүлэлтийн дагуу Их дүнтэй төлбөрийн системийн Банксүлжээ системийг системийн хувьд нэн чухал гэж үзэж байна. Их дүнтэй гүйлгээний дундаж дүн 2017 онд 35,3 сая байсан.

"СЗЗДБ-ийн зарчмууд"-д дурдсанаар оролцогчид болон холбогдох эрх бүхий байгууллагууд нь олон нийтийг шаардлагатай мэдээллээр хангана. Тухайн улс орны хууль эрх зүйн орчинд нийцүүлэн холбогдох эрх бүхий байгууллагууд нь зарчмуудын хэрэгжилт болон үүрэг хариуцлагын биелэлтийг хангах

11

<https://mongolbank.mn/documents/regulation/payme>

ntsystem/2015/20150706.pdf

шаардлагатай. Мөн удирдлагын үүрэг хариуцлагын үнэлгээний гол зорилго нь эрх бүхий байгууллагууд дэд бүтцийн хяналт шалгалт, зохицуулалттай холбоотой үүрэг хариуцлагаа биелүүлж буй эсэх, хэр сайн хэрэгжүүлж байгааг тодорхойлж, биелэлтийг дэмжихэд оршино гэжээ.

ОУТТБ-аас гаргасан Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн 24 зарчим, таван үүрэг хариуцлагын хэрэгжилт их дүнтэй төлбөрийн системийн түвшинд хэрхэн хангагдаж байгааг тодорхойлж, хэрэгжилтийн түвшинг ахиулж, тогтмол хангуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор 2018 онд “Банксүлжээ системийн үнэлгээ”-г хийсэн. Үнэлгээний үр дүнгээс харахад дэд бүтцийн 24 зарчмын 12 зарчим хэрэгжсэн, 5 зарчим ерөнхийдөө хэрэгжсэн, 7 зарчим хамааралгүй байна. Таван үүрэг хариуцлагын А ерөнхийдөө хэрэгжсэн, Б хэсэгчлэн хэрэгжсэн, В болон Г хэрэгжсэн, Д хамааралгүй байна. “Хэрэгжсэн” гэж үнэлээгүй зарчмуудын хувьд анхаарвал зохих асуудлыг шийдвэрлэж, хэрэгжилтийн түвшинг ахиулах талаар системийн операторт зөвлөмж өгсөн.

Түүнчлэн “Төлбөрийн системийн хяналтын бодлого”-д заасны дагуу Монголбанкны хариуцан ажиллуулж буй Төв банкны үнэт

цаасны системд хоёр дахь удаа үнэлгээ хийсэн. Үнэлгээний үр дүнгээс харахад дэд бүтцийн 24 зарчмын 12 зарчим бүрэн хэрэгжсэн, 2 зарчим ерөнхийдөө хэрэгжсэн, 1 зарчим хэсэгчлэн хэрэгжсэн, 9 зарчим хамааралгүй байна.

4. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх

Төлбөр тооцооны газрын Хяналт зохицуулалтын хэлтэс санхүүгийн тогтвортой байдлыг хангахын тулд төлбөрийн системийн эрсдэлийг тодорхойлж, үнэлж, бууруулах арга хэмжээ авч байх шаардлагатай. Энэ нь санхүүгийн зах зээл, цаашлаад эдийн засгийг бүхэлд нь хамарч болох үр дагавартай учраас системийн эрсдэлийг төлбөрийн системийн хяналтын үндсэн асуудал болгон тавьдаг. Иймээс хяналтын тогтолцоог сайтар зохион байгуулснаар төлбөрийн системийн эрсдэлийг бууруулах ач холбогдолтой юм.

5. Шаардлагатай өөрчлөлт хийх

Системийн оролцогчоос ирүүлсэн санал хүсэлт, шалгалтын үр дүн болон үнэлгээний үр дүнг үндэслэн тухайн системийн найдвартай, үр ашигтай байдлын түвшинг хангаж байгаа эсэх тухай дүгнэлт гаргаж, тухайн системд шаардлагатай өөрчлөлтийг хийлгэх арга хэмжээ авдаг.

ХАВСРАЛТ 1

№	Зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Карт гаргах зөвшөөрөл	Карт хүлээн авах зөвшөөрөл	Зөвшөөрөл олгосон хугацаа	Зөвшөөрөл дуусах хугацаа
1	Капитал банк https://capitalbank.mn	₮ карт, Visa, UnionPay	₮ карт, Visa, UnionPay	2010.09.17	2019.09.17
2	Худалдаа хөгжлийн банк http://www.tdbm.mn/mn/	₮ карт, Visa, Mastercard, UnionPay	₮ карт, Visa, Mastercard, UnionPay, JCB, Diners Club, Discover	2010.06.25	2019.06.25
3	Хаан банк https://www.khanbank.com/	₮ карт, Visa, Mastercard, UnionPay	₮ карт, Visa, Mastercard, UnionPay, JCB	2011.12.30	2019.06.30
4	Голомт банк http://www.golomtbank.com/	₮ карт, AMEX, Visa, Mastercard, UnionPay	₮ карт, Visa, Mastercard, UnionPay, AMEX, JCB	2009.12.31	2019.07.01
5	Ариг банк https://www.arigbank.mn	₮ карт, Visa	₮ карт, Visa, UnionPay, JCB, догоодын Mastercard	2012.12.05	2018.12.05

ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН 2018 ОНЫ ХЯНАЛТЫН ТАЙЛАН

6	Улаанбаатар хотын банк http://www.ubcbank.mn/index.php	₮ карт, Visa	₮ карт, Visa, UnionPay, JCB	2010.12.29	2019.12.29
7	Үндэсний хөрөнгө оруулалтын банк http://www.nibank.mn	₮ карт, Visa	₮ карт, UnionPay, Visa, Дотоодын Mastercard, JCB	2013.01.08	2019.01.08
8	Капитрон банк http://www.capitronbank.mn/	₮ карт, Visa, UnionPay	₮ карт, Visa, UnionPay	2012.09.26	хугацаагүй
9	Хас банк http://www.xacbank.mn/	₮ карт, Visa, UnionPay	₮ карт, Visa, UnionPay, JCB,	2011.07.29	2020.08.01
10	Чингис хаан банк http://www.ckbank.mn/	₮ карт, Visa	₮ карт, Visa, Дотоодын UnionPay	2013.04.30	2019.04.30
11	Төрийн банк https://www.statebank.mn/w/mn/	₮ карт, Visa, UnionPay, JCB	₮ карт, Visa, UnionPay, JCB	2014.03.18	2020.03.18
12	Богд банк http://www.bogdbank.com/	₮ карт, Visa	₮ карт, Visa, UnionPay	2016.09.21	2019.09.21
13	Тээвэр хөгжлийн банк http://www.transbank.mn/	₮ карт, UnionPay	₮ карт, UnionPay	2017.11.17	2020.11.17

ХАВСРАЛТ 2

№	Зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрөл олгосон хугацаа	Зөвшөөрөл дуусах хугацаа
1	Мобифинанс ББСБ ХХК http://mobifinance.mn/	Цахим мөнгө гаргах төлбөрийн үйлчилгээ үзүүлэх	2018.09.27	2022.09.27